

Шүүмж

"ММ"-ИЙН СЭТГҮҮЛЧИД МОНГОЛЫН НҮҮР ЦАРАЙ БОЛЖ
ЧАДАХГҮЙ БАЙНА

Г. Гэрэл*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн оюутан, МҮТВ-ийн нэвтрүүлэгч.

Ямарваа улсын нүүр царай, өнгө төрхийг олон зүйлээс харж болох ч үүнд үндэсний телевизийн мэдээллийн хөтөлбөрийн нэвтрүүлэгчид, хөтлөгчид багагүй үүрэг гүйцэтгэдэг. Тэр тусмаа үндэсний телевизээр мэдээ, мэдээллийг уншиж, хөтөлж байгаа нэвтрүүлэгчид улс орны нүүр царай болдог нь арга ч үгүй юм.

Гэтэл Монголын үндэсний телевизийн олон жилийн тэртээгээс улбаатай бодлого зарчим сүүлийн үед алдагдаж "Монголын" гэсэн нүүр царай үгүй болж байна. "ММ" агентлагийн "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөрөөр хөтлөгчид гэх мэргэжлийн бус хэдэн сэтгүүлчид гарч, хазгай муруй ярьж, мэдээллийг ойлгомжгүй уншиж, ёстой эфирээр тоглож, үзэгчдийг үл хүндэтгэж байна.

Сонгуулийн дараа "Эх Орон-Ардчилал" эвслээс Ч.Куландаг МҮТВ-ийн захирлаар, Ц.Мөнхтөрийг "ММ" агентлагийн захирлаар "илгээжээ".

"Бүхнийг шинэчлэлээс эхэлнэ" гэж Ч.Куланда хэвлэл мэдээллийн хэрэгслээр тунхаглаад буй ч шинэхэн захирал маань шинэчилж, өөрчлөх гол зүйлээ олж чадахгүй байгаа нь харамсалтай. Ёстой л

нуухыг нь авах гээд нүдийг нь сохолчихлоо.

Саяхныг хүртэл ажлаа хийж байсан нэвтрүүлэгчдээр мэдээ уншуулахаа больж, оронд нь "ММ"-ийн хэдэн сэтгүүлч бэлтгэсэн мэдээгээ өөрсдөө унших боллоо.

"Цагийн хүрд" хөтөлбөрийн мэдээллийг сэтгүүлчид өөрсдөө уншиж, хөтлөх саналыг Ц.Мөнхтөр захирал тавьж, Ч.Куланда захирал дэмжжээ. Үүнийг дуулаад МҮТВ-д ажиллаж байгаа нэвтрүүлэгчид эсэргүүцэж, нэлээн хэдэн удаа Ч.Куландад өргөдөл барин орсон боловч тэднийг хүлээж аваагүйгээр барахгүй, эцэстээ хэрүүл маргаан болон өнгөрчээ. Сүүлдээ Ч.Куланда "Та нар телевизээр гарахыг хүсч байгаа бол телевизээс цаг аваад нэвтрүүлэг хийхгүй юу. Харин нэвтрүүлгийг чинь маш өндөр шалгуураар шалгана шүү" гэж хэлээд гаргажээ.

Ч.Куланда захирлын энэ "шинэчлэл" нь сонгуулийн үеэр нэр хүнд нь унаж, рейтинг нь буурсан "ММ" агентлагийн хувьд авралын амин тариа болж чадсангүй. Харин ч муу дээрээ муухай, муухай дээрээ улцан гэгч боллоо. Мэдээллийн чанар, бодлогоо сайжруулж чадаагүйгээр барахгүй, мэдээ хөтөлж

байгаа сэтгүүлчид хөтөлбөрийн нэр хүндийг нь улам унагаж, үзэгчдийн тоог цөөлсөөр байна. Уг нь захирлууд болохгүй байгааг нь шинэчлэх, сайжруулах гэж зорьсон нь мэдээж. Харин гаргасан шийдвэр нь үзэгчдэд хэрхэн тусаж байгааг харахад харамсалтай.

Мэдээллийн бодлого, чиглэлээ өөрчилж чадаагүй хирнээ дэмий л нэвтрүүлэгчдийг халж, тайзаа сольсон нь үзэгчдийн төдийгүй, телевизийн уран бүтээлчдийн гайхал, бас дургүйцлийг төрүүлж байна. Дашрамд дурдахад саяхан ашиглалтанд орсон "Цагийн хүрд"-ийн шинэ тайзыг 10 сая төгрөг зарлагдаж хийсэн гэх. Нэг ч их удалгүй бэлэн болсон шинэхэн тайз хуучнаасаа огт дээрдээгүй харагдана. Нүсэр хийгдсэн том тайз өнгө муутай, шинэ лого нь урьдынхаасаа сүргүй, загвар муутай харагдах юм. Нөгөө нэвтрүүлэгчдийг халаад амжилт олоогүй шиг шинэ тайз ч "ММ"-ийг бүр дордууллаа.

Сүүлийн үед "Цагийн хүрд"-ээр мэдээ уншиж байгаа сэтгүүлчдээс хамгийн эфирийн царайтай нь Сүндэр гэдэг. Сэтгүүлчийн хувьд олон жил ажилласан, бусдыгаа бодвол туршлагатай, ажлын практик сайтай бүсгүй. Гэвч мэдээллийг уншиж, хөтлөх чадвар даанч байхгүй. Үзэгчдийг хүндэтгэж эфирийн соёлыг хангадаггүй. Үс зүсээ янзалж, хувцсаа тохируулдаггүй. Мэдээгээ

уншихдаа байн байн ширэв татан харж, өгүүлбэрийн таслал, зогсолт, өргөлтийг ч мэддэггүй нь үзэгчдэд мэдээллээ цэгцтэй, ойлгомжтой хүргэхэд саад учруулж байна. Үнэндээ сонин гүйлгэж уншиж байгаа хүн шиг л хайш яйш уншиж орхидог. Мөн саяхнаас "ММ"-д ажиллаж байгаа сэтгүүлч Батдорж бас л оройн мэдээ унших болсон. Гадаад төрх, дуу хоолой нь даанч гологдмоор энэ ширүүн харцтай

залуу яавч мэдээ уншихад зохицмоор хүн биш байлтай. Гэтэл хэнэг ч үгүй орой болгон үзэгчдийг захирах мэт хэдэн мэдээ уншихаад, ширэв татаад алга болно. Түүний хөтөлж уншсан "Цагийн хүрд"-ийг үзсэний дараа хэн нэгэнд загинуулсан шиг болж, сэтгэл санаа

тавгүй болчих юм. Ёс бус үг хэллэг хэрэглэж, хэтэрхий хурдан ярьж, хэрэлдэж буй мэт өнгө аясаар тэрээр мэдээг уншдаг.

Эдгээр сэтгүүлч, сурвалжлагчид нэвтрүүлэгч болохын хувьд хэтэрхий туршлагагүй, чадваргүй, эфирийн шаардлагад нийцэхгүй байхад тэднийг Монгол орны нүүр царай болгочихоод байгаа телевизийн бодлого баригчид, эрхэм найруулагчид хаана юу хийж явна вэ?

Гэтэл хаа очиж МҮТВ-д өөр аль ч телевизд байхгүй чадварлаг нэвтрүүлэгчид бий.

«

Саяхан ашиглалтанд орсон "Цагийн хүрд"-ийн шинэ тайзыг 10 сая төгрөг зарлагдаж хийсэн гэх.

Нэг ч их удалгүй бэлэн болсон шинэхэн тайз хуучнаасаа огт дээрдээгүй харагдана. Нүсэр хийгдсэн том тайз өнгө муутай, шинэ лого нь урьдынхаасаа сүргүй, загвар муутай харагдах юм. Нөгөө нэвтрүүлэгчдийг халаад амжилт олоогүй шиг шинэ тайз ч "ММ"-ийг бүр дордууллаа.

»

УГЗ Батбаяр, Чимгээ, Ганбаатар, Гантигмаа, Цовоо, Хандаа гээд дурдвал олон. Одоо эдгээр хүмүүс "Цагийн хүрд"-ээр оройн гол мэдээг уншихаа больсон. Зөвхөн Хандаа, Ганбаатар нар ээлжинд гарч унших эрхтэй. Бусад үед "ММ"-ийн "халтар" сэтгүүлчид гарах болсон.

Г адаадынхан Монгол улсын нүүр царайг тэднээр л төсөөлөх боллоо. Яагаад гэвэл бусад телевиз МҮТВ шиг өргөн хүрээнд цацагдах боломжгүй учраас гадаадынханд иймэрхүү л мессеж хүрч байна даа.

Та дэлхийн аль ч орны телевизээс "ММ" агентлаг шиг нэвтрүүлэгчтэй мэдээг олж харахгүй.

Дэлхийн мэдээллийн томоохон телевизүүдийн нэг CNN-ний мэдээний нэвтрүүлэгчээр сүүлийн хэдэн сарын турш Сьюзи (Suesy) ажиллаж, хөтөлбөрийг чадварлаг хөтөлж байна. Харин бусад сэтгүүлч өөр өөрсдийн чиглэлээр мэдээллээ бэлтгэж, хөтөлбөрийн дундуур эфирт гардаг. CNN олон оронд байрладаг өөрийн салбаруудтай. Эдгээр сэтгүүлч эфирт гарах эрхтэй болохын тулд маш өндөр шалгуурыг давдаг. Зах зухаас нь дурдвал англиар цэвэр дуудлагатай, хэллэг тод байх нь эн тэргүүний шалгуур. Ерөнхий хөтөлөх хандлага, мэдээллийг үзэгчдэд соёлтой, зөв хүргэх чадварыг сэтгүүлч бас эзэмшсэн байх ёстой. Энэ бүхнийг давж эфирт гарч мэдээг нэвтрүүлвэл тухайн сэтгүүлчийн карьерт ч маш эерэгээр нөлөөдөг.

Хамгийн ойрын бас нэг жишээ бол ОРТ телевизийн "Время" мэдээллийн хөтөлбөр юм. Нэвтрүүлэгч

лэгч нь Лариса Вербетская бөгөөд долоо дахь жилдээ нэвтрүүлэгчээр ажиллаж байна. ОРТ телевизийн, цаашлаад Орос орны нүүр царай болсон эмэгтэй. "Время" мэдээллийн хөтөлбөр Лариса Вербетскаягаар төсөөлөгдөх жишээтэй.

Манай улсын хувьд 1967 оны 9-р сарын 27-нд анхныхаа эфирийг цацаж эхэлснээс хойш бүхий л хугацаанд мэргэжлийн нэвтрүүлэгчид ажиллаж, Монгол орны нүүр царайг илтгэж, мэдээг мэргэжлийн төвшинд уншиж үзэгчдэд хүргэж байлаа. УГЗ Чулуунбат, Хишгээ, Цэеэнханд, Батсүрэн, Бямба, Нарантуяа гээд жинхэнэ мэргэжлийн нэвтрүүлэгчид МҮТВ-д ажиллаж, мэдээ уншиж, эх орны нэрийн хуудас болсоор ирсэн.

Одоо харин энэ уламжлал, бодлого алдагдаж, Монголын үндэсний телевизийн, цаашлаад Монгол орны нүүр царай үгүй боллоо.

Юм л бол гадаадынхныг үлгэр, загвар болгож, болсон болоогүй бүгдийг нь дууриадаг "монгол сэтгэлгээ" даанч өрөвдөлтэй. Цаад учир шалтгаан, зохицол, уран бүтээлчид, ажилчдын чадварыг харгалзан үзэлгүйгээр аялдан дууриаж, хэлбэр төдий, нэр зүүсэн шинэчлэл хийх нь даан ч оновчгүй, "нүглийн нүдийг гурилаар хуурсан" мэт.

Ард түмний дуу хоолой, индэр байх ёстой Монголын Үндэсний Телевизийг өөрчлөн шинэчилж, жинхэнэ ёсоор нь хөгжүүлье гэвэл эхлээд мэдээллийн бодлого зарчим, засгаас хараат байдлыг бүрэн халах нь эн тэргүүний зорилт болоод байна.